



МОНГОЛ УЛСЫН  
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН  
ТУШААЛ

2025 оны 01 сарын 10 өдөр

Дугаар А/33

Улаанбаатар хот


Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 97 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрмийн 2.5, мөн тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Дулааны эрчим хүч хэрэглэх дүрмийн 2.4-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Цахилгаан, дулааны техникийн нөхцөлийн хүсэлтийг цахим системээр шийдвэрлэх ажлын хэсгийн ажиллах журмыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга (Б.Насантогтох)-д үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаал, 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/116 дугаар тушаал, 2024 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/209 дүгээр тушаалын 2 дугаар заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

170600600084

Эрчим хүчний сайдын 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 423 дугаар тушаалын хавсралт



ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙН ХҮСЭЛТИЙГ ЦАХИМ  
СИСТЕМЭЭР ШИЙДВЭРЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН  
АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар иргэн, хуулийн этгээдийн цахилгаан, дулааны техникийн нөхцөл (цаашид “техникийн нөхцөл” гэх) хүссэн хүсэлтийг цахим системээр хүлээн авах, судлах, холбогдох шийдвэрийг гаргах, хариу хүргүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Цахим систем нь [www.itc.energy.mn](http://www.itc.energy.mn) гэсэн хаягтай байх бөгөөд системийн үйл ажиллагааг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоол, 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 100 дугаар тогтоол, 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 197 дугаар тогтоолыг тус тус үндэслэн зохион байгуулна.

1.3. “Цахим системийн мэдээллийн дата бааз” нь цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх хангах тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн эзэмшил, ашиглалтын хүрээнд хамаарах үндсэн тоноглол, цахилгаан дулааны эрчим хүч дамжуулах, түгээх шугам, дэд станцуудад жил бүрийн өвлийн оргил ачааллын үед хэмжилт хийж тогтоосон техникийн үндсэн үзүүлэлт бүхий мэдээлэлд үндэслэгдсэн байна.

Хоёр. Цахим системээр ажиллах бүрэлдэхүүн

2.1. Техникийн нөхцөлийн хүсэлтийг цахим системээр шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- 2.1.1. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага;
- 2.1.2. Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч;
- 2.1.3. Цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч;
- 2.1.4. Цахилгаан, дулааны эрчим хүч дамжуулах тусгай зөвшөөрөл эзэмшигч;
- 2.1.5. Цахилгаан, дулааны эрчим хүч түгээх тусгай зөвшөөрөл эзэмшигч;

Гурав. Цахим системээр ажиллах бүрэлдэхүүний эрх, үүрэг

3.1. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан, дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 1.4-т заасны дагуу цахим системээр ирүүлсэн хүсэлтийг хянах, буцаах, тооцоо судалгаа хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагад шилжүүлэх,

тооцооны дүгнэлт саналыг үндэслэн техникийн нөхцөлийг хянаж баталгаажуулах эрхтэй байна.

3.2. Журмын 2.1.2, 2.1.3, 2.1.4, 2.1.5-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нар нь 1.3-т заасан "Цахим системийн мэдээллийн дата бааз"-ыг үндэслэн хүсэлтийг буцаах эрхтэй байна.

3.3. Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.6.2, 2.6.3, "Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.5.2, 2.5.3-т заасан хүсэлтийн тооцоо судалгааг хийж дүгнэлт саналыг цахим системд оруулах үүрэгтэй байна.

3.3. Журмын 2.1.3, 2.1.4, 2.1.5-д заасан тусгай зөвшөөрөл эзэмшигч нар нь өөрийн эзэмшил, ашиглалтын хүрээнд хамаарах үндсэн тоноглол, цахилгаан дулааны эрчим хүч дамжуулах, түгээх шугам, дэд станцуудаас хангагдах хүсэлтийн тооцоо судалгааг хийж дүгнэлт саналыг цахим системд оруулах үүрэгтэй байна.

3.4. Диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь "Цахим системийн мэдээллийн дата бааз"-ыг жил бүр шинэчилж системд оруулах үүрэгтэй байна.

3.5. Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь иргэн хуулийн этгээдийн техникийн нөхцөл хүссэн хүсэлтийн хэрхэн шийдвэрлэсэн талаар цахим системээр хариу өгөх үүрэгтэй байна.

#### Дөрөв. Цахим системийн үндсэн үйл ажиллагаа

4.1. Журмын 1.1-д заасан үйл ажиллагаа нь Хавсралт-1-д заасан үндсэн бүдүүвч схемийн дагуу явагдана.

4.2. Цахим системд хүсэлт илгээхэд иргэн, хуулийн этгээд нь төрийн үйлчилгээний танилт, нэвтрэлтийн системээр дамжин нэвтрэнэ.

4.3. Иргэн, хуулийн этгээдээс цахим системээр ирүүлсэн техникийн нөхцөлийн хүсэлтийг "Цахилгаан, дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм"-ийн 2.1 дэхь хэсэгт заасан баримт бичгийн бүрдэлийг хангасан эсэхийг хянан хүлээн авна.

4.4. Цахим системийн үйл ажиллагааг зохион байгуулж буй бүрэлдэхүүн нь техникийн нөхцөлийн хүсэлттэй танилцах, хянах, баталгаажуулах ажлыг тогтмол цахим системээр гүйцэтгэнэ.

#### Тав. Баталгаажуулах

5.1. Журмын 1.3, 2.1, 3.1, 3.2-д заасны дагуу дагуу хянан баталгаажуулах үйл ажиллагааг зохион байгуулж холбогдох хариуг цахим системээр хүргүүлнэ.

5.2. Техникийн нөхцөл олгохоос татгалзсан тохиолдолд мөн хариуг цахим системээр хүргүүлнэ.

5.3. Техникийн нөхцөл нь цахим хэлбэрээр олгогдох бөгөөд нууцлалын QR кодоор баталгаажсан байна.

5.4. Иргэн, хуулийн этгээд нь Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Цахилгаан эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.18 дахь хэсэг, “Дулааны эрчим хүч хэрэглэх дүрэм”-ийн 2.14 дэх хэсэгт заасны дагуу үйлчилгээний төлбөр (хураамж) төлнө.

#### Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

\_\_\_oOo\_\_\_

ПРОГРАММЫН ҮНДСЭН БҮДҮҮВЧ СХЕМ

